**УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

---

# Өлгий сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** УВА-2023/06/НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас:<br>www.audit.mn<br>Улаангом хот<br>2023 он | Увс аймаг дахь Төрийн аудитын газар,<br>Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь<br>Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn<br>Аудитын менежер: М.Бат-Амгалан<br>Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn<br>Аудитор: А.Нанжидмаа<br>Утас: 70453799, Цахим хаяг: Nanjidmaaa@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

Дүгнэлтийн үндэслэл ..... 3
Асуудлыг онцолсон хэсэг ..... 3
Аудитын гол асуудал ..... 3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ ..... 5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА ..... 12
4.1 Ерөнхий зүйл ..... 15
4.2 Материаллаг байдал ..... 15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт ..... 15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..... 16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ..... 16
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд ..... 16
4.5.1 Завсрын аудитын талаар ..... 16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ..... 16
Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй. ..... 16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ ..... 16
5.1 Төлбөрийн акт ..... 17

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| НА | Нийцлийн аудит |

ӨЛГИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Ш.ДҮҮРЭНБИЛЭГ ТАНАА


УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn


2023.02.24 № УВА-2023/06/НА-СПАТ 443

танай ______ -ны № ______ -т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өлгий сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Өлгий сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой, санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээлэл байхгүй болно.

**Аудитын гол асуудал**

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

0200000607

### Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.БАТСУУРЬ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөг/

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **64,221,077.03** | **86,087,634.65** |
| **33** | **АВЛАГА** | **6,706,884.63** | **9,887,241.00** |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 3,506,884.63 | 2,127,946.00 |
| **33500** | **Бусад авлага** | **3,200,000.00** | **7,759,295.00** |
| 33510 | Байгууллагаас авах авлага | 3,200,000.00 | 7,759,295.00 |
| **34** | **УРЬДЧИЛГАА** | **150,000.00** | **0.00** |
| **34710** | **Урьдчилгаа тооцоо** | **150,000.00** | **0.00** |
| 34714 | Томилолтын урьдчилгаа | 150,000.00 | 0.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **57,364,192.40** | **76,200,393.65** |
| **35400** | **Хангамжийн материал** | **57,364,192.40** | **72,203,060.65** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 374,800.00 | 373,500.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 32,231,626.00 | 29,034,794.25 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 24,757,766.40 | 42,794,766.40 |
| 35600 | Мал амьтад | 0.00 | 3,997,333.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **2,050,226,874.81** | **2,292,216,779.61** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **2,050,226,874.81** | **2,292,216,779.61** |
| **39200** | **Биет хөрөнгө** | **2,017,502,874.85** | **2,233,492,613.02** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 988,754,385.42 | 1,083,339,419.42 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -237,201,888.77 | -245,397,205.81 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 96,416,058.00 | 152,616,058.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -86,303,627.19 | -86,303,627.19 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 101,615,151.40 | 130,475,901.40 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -32,721,678.13 | -34,051,721.78 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 80,037,870.00 | 80,637,870.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -22,202,178.85 | -29,494,568.30 |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 931,055,661.00 | 931,055,661.00 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 296,369,988.00 | 352,215,988.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -98,316,866.03 | -101,601,161.72 |
| **39300** | **Биет бус хөрөнгө** | **32,723,999.96** | **58,724,166.59** |
| 39301 | Програм хангамж | 2,360,000.00 | 2,360,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -1,694,000.04 | -1,761,833.41 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 32,058,000.00 | 58,126,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **2,114,447,951.84** | **2,378,304,414.26** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **14,104,075.00** | **16,346,025.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **14,104,075.00** | **16,346,025.00** |
| **41300** | **Өглөг** | **14,104,075.00** | **16,346,025.00** |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 1,500.00 | 112,500.00 |
| **41360** | **Бусад өглөг** | **14,102,575.00** | **16,233,525.00** |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 14,102,575.00 | 14,466,825.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 0.00 | 1,766,700.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **2,100,343,876.84** | **2,361,958,389.26** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **2,100,343,876.84** | **2,361,958,389.26** |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 455,623,311.17 | 455,623,311.17 |
| 511002 | Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө | 455,623,311.17 | 455,623,311.17 |
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | **1,025,279,635.99** | **1,286,894,148.41** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 871,480,724.33 | 1,025,279,635.99 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 153,798,911.66 | 261,614,512.42 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 619,440,929.68 | 619,440,929.68 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **2,114,447,951.84** | **2,378,304,414.26** |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

/төгрөг/

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **688,584,057.21** | **710,249,845.25** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **278,911,171.21** | **149,914,611.25** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **278,911,171.21** | **149,914,611.25** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **278,911,171.21** | **149,914,611.25** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 3,363,431.21 | 3,354,960.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 275,547,740.00 | 146,559,651.25 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **409,672,886.00** | **560,335,234.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **7,138,086.00** | **137,351,034.00** |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 0.00 | 137,351,034.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,750,000.00 | 0.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 5,388,086.00 | 0.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **402,534,800.00** | **422,984,200.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 402,534,800.00 | 422,984,200.00 |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **512,341,210.66** | **448,635,332.83** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **512,341,210.66** | **448,635,332.83** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **480,699,318.30** | **425,609,439.05** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **242,664,390.33** | **256,569,821.83** |
| 210101 | Үндсэн цалин | 208,788,378.33 | 238,039,321.83 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 33,876,012.00 | 18,530,500.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **27,547,364.96** | **31,893,301.02** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 17,958,267.55 | 24,116,097.58 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,397,299.42 | 2,006,369.27 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,917,799.14 | 1,607,215.52 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 479,499.71 | 387,105.22 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,794,499.14 | 3,776,513.43 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **46,198,682.93** | **43,072,900.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,248,311.93 | 2,957,466.00 |
| 210302 | Түлш, халаалт | 42,900,371.00 | 40,115,434.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 50,000.00 | 0.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **37,729,260.00** | **44,741,595.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 6,193,450.00 | 10,829,230.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 18,087,450.00 | 23,941,145.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,254,000.00 | 1,588,650.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 797,650.00 | 0.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 11,396,710.00 | 8,382,570.00 |
| **2105** | **Норматив зардал** | **3,821,500.00** | **632,700.00** |
| 210502 | Хоол, хүнс | 3,821,500.00 | 0.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 0.00 | 632,700.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **9,885,030.00** | **5,367,600.00** |
| 210604 | Урсгал засвар | 9,885,030.00 | 5,367,600.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **3,308,000.00** | **4,541,600.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,308,000.00 | 4,541,600.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **1,446,972.00** | **3,961,537.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 0.00 | 1,538,090.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 288,000.00 | 288,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 108,900.00 | 535,735.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 107,272.00 | 25,900.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 22,000.00 | 0.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 813,500.00 | 876,300.00 |
| 210807 | Газрын төлбөр | 107,300.00 | 697,512.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **108,098,118.08** | **34,828,384.20** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 18,358,251.00 | 13,736,505.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 240,000.00 | 922,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 89,499,867.08 | 20,169,879.20 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **31,641,892.36** | **23,025,893.78** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **27,623,429.00** | **20,194,358.00** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 11,653,320.00 | 17,664,358.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 15,117,300.00 | 2,520,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 852,809.00 | 10,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **4,018,463.36** | **2,831,535.78** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 3,107,578.36 | 2,831,535.78 |
| 213405 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 910,885.00 | 0.00 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **176,242,846.55** | **261,614,512.42** |
| **IV** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН** | **931,055,661.00** | **0.00** |
| 145003 | Хөрөнгө оруулалтын олз | 931,055,661.00 | 0.00 |
| **V** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **953,499,595.89** | **0.00** |
| 225001 | Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз | 6,132,032.89 | 0.00 |
| 225010 | Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө | 947,367,563.00 | 0.00 |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | **153,798,911.66** | **261,614,512.42** |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

**/төгрөг/**

| **Дансны код** | **Үзүүлэлт** | **Өмнөх оны гүйцэтгэл** | **Тайлант оны гүйцэтгэл** |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **413,036,317.21** | **563,690,194.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **3,363,431.21** | **3,139,680.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 3,363,431.21 | 3,139,680.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 3,363,431.21 | 3,139,680.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 3,363,431.21 | 3,139,680.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **409,672,886.00** | **560,550,514.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 7,138,086.00 | 137,351,034.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 137,351,034.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 7,138,086.00 | 00.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 402,534,800.00 | 423,199,480.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 402,534,800.00 | 423,199,480.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **413,036,526.21** | **563,690,194.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **413,036,526.21** | **563,690,194.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **381,415,133.85** | **540,771,358.22** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 239,722,780.96 | 254,912,245.13 |
| 210101 | Үндсэн цалин | 201,443,240.41 | 219,169,576.47 |
| 210102 | Нэмэгдэл | 00.00 | 29,993,988.66 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 38,279,540.55 | 5,748,680.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 32,363,196.96 | 31,971,939.09 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 22,774,099.55 | 21,741,328.95 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,397,299.42 | 2,557,756.27 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,917,799.14 | 2,045,995.52 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 479,499.71 | 511,405.22 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,794,499.14 | 5,115,453.13 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 45,189,482.93 | 45,198,100.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,248,311.93 | 2,703,091.00 |
| 210302 | Түлш, халаалт | 41,891,171.00 | 42,183,009.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 50,000.00 | 312,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 19,470,350.00 | 36,801,285.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,668,550.00 | 9,206,340.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 12,468,600.00 | 19,722,685.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,302,000.00 | 1,608,790.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 1,300,000.00 | 00.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 416,000.00 | 250,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,315,200.00 | 6,013,470.00 |
| **2105** | **Норматив зардал** | 849,000.00 | 849,700.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 849,000.00 | 849,700.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 6,500,800.00 | 5,220,800.00 |
| 210604 | Урсгал засвар | 6,500,800.00 | 5,220,800.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 3,458,000.00 | 2,824,900.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,458,000.00 | 2,824,900.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,724,472.00 | 3,986,455.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 250,000.00 | 1,601,500.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 288,000.00 | 288,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 108,900.00 | 176,568.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 107,272.00 | 335,292.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 22,000.00 | 77,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 841,000.00 | 916,300.00 |
| 210807 | Газрын төлбөр | 107,300.00 | 591,795.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 32,137,051.00 | 159,005,934.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 31,859,251.00 | 157,527,434.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 277,800.00 | 1,478,500.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **31,621,392.36** | **22,918,835.78** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 27,602,929.00 | 20,087,300.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 11,653,320.00 | 16,737,300.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 15,117,300.00 | 2,520,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 832,309.00 | 830,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 4,018,463.36 | 2,831,535.78 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 4,018,463.36 | 2,831,535.78 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **-209.00** | **00.00** |
| | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **00.00** | **00.00** |
| **4** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)** | **00.00** | **00.00** |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **00.00** | **00.00** |
| | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **00.00** | **00.00** |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **00.00** | **00.00** |

| | | | |
|---|---|---|---|
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | -209.00 | 00.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 209.00 | 00.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 00.00 |

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

**/төгрөг/**

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| **1** | **2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл** | 433,038,811.17 | 359,523,478.07 | -109,662,119.17 | 682,900,170.07 |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0 | 0 | 0.0 | 0.00 |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | **433,038,811.17** | **359,523,478.07** | **-109,662,119.17** | 682,900,170.07 |
| 4 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | 0 | | 0 | -45,619.80 |
| 5 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | 0 | 0 | 0 | 0 |
| 6 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0 | 0 | 0 | 0 |
| 7 | Өмчид гарсан өөрчлөлт | 0 | 0 | 0 | 0 |
| 8 | Зарласан ногдол ашиг | 0 | 0 | 0 | 0 |
| 9 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 5,112,874.06 | 5,112,874.06 |
| **10** | **2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл** | **455,623,311.17** | **619,440,929.68** | **1,025,279,635.99** | 2,100,343,876.84 |
| **11** | **2022 оны 1-р сарын 1-ний үлдэгдэл** | **455,623,311.17** | **619,440,929.68** | **1,025,279,635.99** | 2,100,343,876.84 |
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 13 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | **455,623,311.17** | **619,440,929.68** | **1,025,279,635.99** | 2,100,343,876.84 |
| 14 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | 0 | 0 | 0 | 0 |
| 15 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | 0 | 0 | 0 | 0 |
| 16 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0 | 0 | 0 | 0 |
| 17 | Өмчид гарсан өөрчлөлт | 0 | 0 | 0 | 0 |
| 18 | Зарласан ногдол ашиг | 0 | 0 | 0 | 0 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 261,614,512.42 | 261,614,512.42 |
| **20** | **2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл** | **455,623,311.17** | **619,440,929.68** | **1,286,894,148.41** | **2,361,958,389.26** |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **424,734,200.00** | **423,507,624.22** | **1,226,575.78** | **99.71** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **424,734,200.00** | **423,507,624.22** | **423,507,624.22** | **99.71** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **404,643,900.00** | **403,420,324.22** | **403,420,324.22** | **99.70** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **255,782,200.00** | **254,912,245.13** | **254,912,245.13** | **99.66** |
| 210101 | Үндсэн цалин | 230,582,200.00 | 219,169,576.47 | 219,169,576.47 | **95.05** |
| 210102 | Нэмэгдэл | 0.00 | 29,993,988.66 | 29,993,988.66 | **0.00** |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 25,200,000.00 | 5,748,680.00 | 5,748,680.00 | **22.81** |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **31,972,700.00** | **31,971,939.09** | **31,971,939.09** | **100.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 21,741,400.00 | 21,741,328.95 | 21,741,328.95 | **100.00** |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,557,900.00 | 2,557,756.27 | 2,557,756.27 | **99.99** |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,046,200.00 | 2,045,995.52 | 2,045,995.52 | **99.99** |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 511,600.00 | 511,405.22 | 511,405.22 | **99.96** |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,115,600.00 | 5,115,453.13 | 5,115,453.13 | **100.00** |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **45,198,300.00** | **45,198,100.00** | **45,198,100.00** | **100.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,461,400.00 | 7,560,791.00 | 7,560,791.00 | **169.47** |
| 210302 | Түлш, халаалт | 40,636,900.00 | 37,325,309.00 | 37,325,309.00 | **91.85** |
| 210303 | Цэвэр, бохир ус | 100,000.00 | 312,000.00 | 312,000.00 | **0.00** |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **35,716,900.00** | **35,461,285.00** | **35,461,285.00** | **99.28** |
| 210401 | Бичиг хэрэг | 9,153,700.00 | 9,206,340.00 | 9,206,340.00 | **100.58** |
| 210402 | Тээвэр, шатахуун | 18,819,600.00 | 18,382,685.00 | 18,382,685.00 | **97.68** |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,634,500.00 | 1,608,790.00 | 1,608,790.00 | **61.07** |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 500,000.00 | 250,000.00 | 250,000.00 | **50.00** |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,609,100.00 | 6,013,470.00 | 6,013,470.00 | **130.47** |
| **2105** | **Нормативт зардал** | **849,700.00** | **849,700.00** | **849,700.00** | **100.00** |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 849,700.00 | 849,700.00 | 849,700.00 | **100.00** |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **5,220,800.00** | **5,220,800.00** | **5,220,800.00** | **100.00** |
| 210604 | Урсгал засвар | 5,220,800.00 | 5,220,800.00 | 5,220,800.00 | **100.00** |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **2,824,900.00** | **2,824,900.00** | **2,824,900.00** | **100.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,824,900.00 | 2,824,900.00 | 2,824,900.00 | **100.00** |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **4,061,900.00** | **3,986,455.00** | **3,986,455.00** | **98.14** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,733,000.00 | 1,729,500.00 | 1,729,500.00 | **99.80** |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 160,000.00 | 160,000.00 | 160,000.00 | **100.00** |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 215,500.00 | 143,568.00 | 143,568.00 | **66.62** |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 404,100.00 | 404,092.00 | 404,092.00 | **100.00** |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 110,000.00 | 110,000.00 | 110,000.00 | **100.00** |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 916,300.00 | 916,300.00 | 916,300.00 | **100.00** |
| 210807 | Газрын төлбөр | 523,000.00 | 522,995.00 | 522,995.00 | **100.00** |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **23,016,500.00** | **22,994,900.00** | **22,994,900.00** | **99.91** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 22,600,000.00 | 22,578,400.00 | 22,578,400.00 | **99.90** |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 416,500.00 | 416,500.00 | 416,500.00 | **100.00** |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **20,090,300.00** | **20,087,300.00** | **20,087,300.00** | **99.99** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **20,090,300.00** | **20,087,300.00** | **20,087,300.00** | **99.99** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 16,737,300.00 | 16,737,300.00 | 16,737,300.00 | **100.00** |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 2,520,000.00 | 2,520,000.00 | 2,520,000.00 | **100.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 833,000.00 | 830,000.00 | 830,000.00 | **99.64** |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **424,734,200.00** | **423,507,624.22** | **423,507,624.22** | **99.71** |
| **32** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **423,234,200.00** | **420,152,664.22** | **0.00** | **99.27** |
| 320001 | Орон нутгийн төсвөөс | 423,234,200.00 | 420,152,664.22 | 0.00 | **99.27** |
| **35** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **1,500,000.00** | **3,354,960.00** | **3,354,960.00** | **223.66** |
| 350001 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,500,000.00 | 3,354,960.00 | 3,354,960.00 | **223.66** |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | **1.00** | **1.00** | **0.00** | **100.00** |
| 610001 | Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 | 0.00 | **100.00** |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | **27.00** | **27.00** | **0.00** | **100.00** |
| 620001 | Удирдах ажилтан | 7.00 | 7.00 | 0.00 | **100.00** |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 10.00 | 10.00 | 0.00 | **100.00** |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 2.00 | 2.00 | 0.00 | **100.00** |
| 620004 | Гэрээт ажилтан | 8.00 | 8.00 | 0.00 | **100.00** |

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

**/төгрөг/**

| | | |
|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **137,351,034.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **137,351,034.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **137,351,034.00** |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 1,340,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 136,011,034.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 134,411,034.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,600,000.00 |
| **I** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **137,351,034.00** |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 137,351,034.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | **137,351,034.00** |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Орон нутгийн удирдлагыг мэдээлэл, бодлогын удирдамжаар ханган хууль тогтоомж, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохицуулан сумын эдийн засаг, нийгмийн хөгжлийг хангаж, төрийн үйлчилгээг иргэдэд ил тод нээлттэй, чанар, хүртээмжтэй хүргэх зорилготой байгууллага юм.

Тамгын газрын чиг үүргийн хувьд орон нутагт төрийн захиргааны удирдлага, төлөвлөлт санхүү, эдийн засгийн бодлого, нийгмийн бодлогын асуудлыг хариуцан төрийн хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, түүний хэрэгжилтийг хангуулах төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээг хуулийн дагуу түргэн шуурхай, чанартай хүргэх, иргэдийн ажиллаж амьдрах таатай орчин бүрдүүлэхэд гол анхаарал хандуулан ажиллаж байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль,

Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн тухай хууль, бусад хууль, тогтоомжуудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Хөдөлмөрийн тухай хууль - Шинэчлэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль - 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсан.
- ✓ Төрийн албаны тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 05-ны өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр нэмэлт өөрчлөлтүүд оруулсан байна.
- ✓ Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 01-ний өдөр, 8 дугаар сарын 29-ний өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

**3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Увс аймгийн Өлгий сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн бөгөөд байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

**3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Увс аймгийн Өлгий сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэлээ.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн аливаа бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 241,989.9 мянган төгрөгөөр буюу 11.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 0.0 | 0.0 | 0.0 |
| Авлага | 6,706.8 | 9,429.7 | 2,722.9 |
| Бараа материал | 57,364.1 | 76,200.3 | 18,836.2 |
| Үндсэн хөрөнгө | 2,050,824.6 | 2,292,216.7 | 241,989.9 |
| **Нийт хөрөнгө** | 2,114,447.9 | 2,378,304.4 | 263,856.4 |
| Өр төлбөр | 14,104.0 | 16,093,3 | 1,989.3 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 2,100,941.6 | 2,361,958.4 | 261,614.5 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 2.114.447.9 | 2,378,304.4 | 263,856.4 |

Авлага дансны үлдэгдэл 2,722.9 мянган төгрөгөөр өссөн нь байгаль хамгаалах сангийн авлага 7,759.3 мянга төгрөг шилжиж ирсэн, хувь хүний орлогын албан татвар, цалингийн урьдчилгаа, томилолтын урьдчилгааны авлагаас шалтгаалсан байна.

Бараа материал дансны үлдэгдэл 76,200.3 мянган төгрөг болж 18,836.2 мянган төгрөгөөр өссөн нь бусад хангамжийн материал орлого авсан хөрөнгөөс шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,292,216.7 мянган төгрөг болж 241,989.9 мянган төгрөгөөр өссөн нь 236,091.7 мянган төгрөгийн үнэ төлбөргүй хүлээн авсан болон төсвийн худалдан авсан хөрөнгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 1,989.3 мянган төгрөгөөр өссөн нь ажилчидтай холбогдсон, байгууллагад төлөх өглөг нэмэгдсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,361,958.4 мянган төгрөг болж 261,614.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ. Энэ нь хөрөнгө өссөнтэй холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон төсвөөс 580,215.2 мянга, давсан орлогоос 1,500.0 мянга, нийт 581,715.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналыг 173,935.9 мянган төгрөгөөр бууруулж 407,779.3 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь тээвэр шатахуун, бараа үйлчилгээний бусад зардлыг нэмэгдүүлсэн байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 16,954.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 13 арга хэмжээг

санхүүжүүлэхээр орон нутгийн төсвөөс 424,839.1 мянга, үйл ажиллагааны орлогоос 1,500.0 мянга, нийт 426,339.1 мянган төгрөгийн орлого бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр орон төсвөөс 423,507.6 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 420,676.1 мянган төгрөг буюу 99.3 хувьтай байгаа нь үндсэн данс хэмнэгдсэн байна. Үндсэн данснаас 2,831.5 мянган төгрөг төвлөрүүлсэн байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 218,626.30 | 216,698.40 | 1,927.8 | 99.1% |
| 2 | Баг хорооны үйл ажиллагаа | 71,499.10 | 70,620.60 | 0.8 | 98.7% |
| 3 | Төрийн өмчийн барилгын тогтмол зарлага | 48,048.90 | 48,048.70 | 0.2 | 99.9% |
| 4 | Нийтлэг үйлчилгээ | 40,419.6 | 40,419.1 | 0.4 | 99.9% |
| 5 | Мэдээлэл сурталчилгааны зардал | 1,450.0 | 1,450.0 | 0.00 | 100% |
| 6 | Ажил олгогчоос олгох тэтгэмж | 16,737.3 | 16,737.3 | 0.00 | 100% |
| 7 | Орон нутгийн нөөц | 16,200.0 | 16,200.0 | 0.00 | 100% |
| 8 | Мал тооллого | 1,800.0 | 1,778.4 | 21.6 | 98.8% |
| 9 | Ахмадын сан | 600.0 | 600.0 | 0.00 | 100% |
| 10 | Сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдсөн албан хаагчид олгох нөхөн олговор | 16,737.3 | 16,737.3 | 0.00 | 100% |
| 11 | Хог хаягдал, орчны бохирдлыг устгах, цэвэрлэх үйлчилгээ | 500.0 | 250.0 | 250.0 | 50% |
| 12 | Улсын баяр наадам | 4,000.0 | 4,000.0 | 0.00 | 100% |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй

ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 137,351.0 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна.

Үүнээс бараа үйлчилгээний бусад зардалд 136,031.5 мянга, тээвэр шатахууны зардалд 1,340.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Өлгий сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал,

дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор А.Нанжидмаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Өлгий сумын Засаг даргын тамгын газар нь 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 01/02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

**4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 512,341.2 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 5,123.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 448,635.3 мянган төгрөгийн 1 хувиар буюу 4,486.3 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 3,589.0 мянган төгрөгөөр тогтоолоо.

**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Өлгий сумын Засаг даргын тамгын газрын хувьд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.5 дахь заалт “Төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах”гэж заасныг зөрчин Засаг даргын нөөц хөрөнгөөс ахмад, нутгийн зөвлөлийн гишүүдэд зориулж 430.8 мянган төгрөгийн бэлэг дурсгалын зүйл худалдан авсан байна.

**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа байршуулсан 145 мэдээлэл, хугацаа хоцроосон 4 мэдээлэл, байршуулах хугацаа болоогүй 2 мэдээлэл байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

**4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

1. Өлгий сумын Засаг даргын тамгын газар нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь хэсэгт “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг

хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Өлгий сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд хийсэн завсрын аудитаар алдаа зөрчил илрээгүй болно.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 698.6 мянган төгрөгийн 1 төлбөрийн актыг барагдуулж биелэлтийг ирүүлсэн байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 1 | 698.6 | 1 | 698.6 | **100** |
| Албан шаардлага | | | | | |
| Зөвлөмж | | | | | |
| **Нийт дүн** | 1 | 698.6 | 1 | 698.6 | **100** |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 430.8 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 430.8 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоолоо. Үүнд:

### 5.1 Төлбөрийн акт

Засаг даргын нөөц хөрөнгөөс ахмад, нутгийн зөвлөлийн гишүүдэд зориулж 430.8 мянган төгрөгийн бэлэг дурсгалын зүйл худалдан авч төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, ”, 16.5.5 дахь заалт “Батлагдсан төсвийн зориулалтын дагуу зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.5 дахь заалт “Төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах”, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.3-т “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал

(цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх" гэж тус тус заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн: Төлбөрийн акт тогтоох

---

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Бэлэг дурсгалын зүйлд зарцуулсан | 1 | 430.8 | 1 | 430.8 | | | | | | | | |
| Дүн | **1** | 430.8 | 1 | 430.8 | | | | | | | | |

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

<u>АУДИТЫН ТАЙЛАНГ</u>

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН: АУДИТОР /А.НАНЖИДМАА/

2023 оны 02 дугаар сарын 18-ны өдөр

**УВС АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АКТ**

2023 оны 02 сарын 24 өдөр Дугаар 01/11/А2070416 ҮВА-2023/06/НА-СТА-ТШЗ Улаангом

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Өлгий сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төсвийн хөрөнгөөр 430800 төгрөгийн бэлэг дурсгалын зүйл авч төсвийг үр ашиггүй, арвилан хэмнэлтгүй зарцуулсан зөрчил илэрлээ.

Энэ ньТөсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, 16.5.5 дахь заалт “Батлагдсан төсвийн зориулалтын дагуу зарцуулах” Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.5 дахь заалт “Төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах”, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.3-т “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх” гэж тус тус заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсэг “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3-д “Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэж заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төсвийн хөрөнгөөр худалдан авсан бэлэг дурсгалын зүйлийн үнэ 430800 /Дөрвөн зуун гучин мянга найман зуу/ төгрөгийг Өлгий сумын Засаг дарга Ж.Очирбатаар төлүүлж Төрийн сан банкин дахь орон нутгийн орлогын 100150000962 тоот дансанд төвлөрүүлэх.

[1]Увс аймаг, Улаангом сум, 3 дугаар баг, Ө.Бадрахын гудамж, аймгийн Засаг Даргын Тамгын газрын байр, 304 тоот, Утас: 70453317

0200500064

2. Актын биелэлтийг 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн дотор Увс аймаг дахь Төрийн аудитын газар[1]т ирүүлэхийг Өлгий сумын Засаг дарга Ж.Очирбат, Засаг даргын тамгын газрын дарга Ш.Дүүрэнбилэг, нягтлан бодогч Б.Сүнжидмаа нарт хариуцуулав.

3. Төлбөрийн актыг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд Захиргааны ерөнхий хуулийн 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэгт заасны дагуу гомдол гаргах эрхтэй.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТОР А.НАНЖИДМАА

АУДИТЫН МЕНЕЖЕР М.БАТ-АМГАЛАН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.БАТСУУРЬ